

Понзи схем

- Бага эсвэл ямар ч эрсдэлгүй өгөөж амладаг
- Тусгай зөвшөөрөлгүй үйл ажиллагаа явуулдаг
 - Нууцлагдмал, тодорхой мэдээлэлгүй
 - Хэт тогтмол өгөөжтэй байдаг

Урьдчилгаа төлбөрт луйвар


- Урьдчилан **төлбөр төлөхийг яаруулдаг**
- Судлах материал хомс

Санхүүгийн пирамид

- Шинээр гишүүн элсүүлэхийг шаарддаг
- Бодит бүтээгдэхүүн, үйлчилгээ борлуулдаггүй
- **Богино хугацаанд өндөр өгөөж амладаг**



Сургалтын луйвар



Памп & Дамп

- Биелэхэд хэцүү зүйлийг **амархан мэтээр үнэмшүүлдэг**
- Өөр газраас үнэгүй олох **мэдээллийг өндөр үнээр** санал болгодог
- Яаруулж, бодох хугацаа олгодоггүй
- Дараа дараагийн сургалтад илүү өндөр үнээр хамрагдахыг шаарддаг
- **Хуурамч мэдээлэл** ашиглан сурталчилгаа хийдэг

- **Зохицуулалт багатай** зах зээл рүү чиглэдэг
- **Богино хугацаанд өндөр өгөөж амладаг**
- Зохицуулалт багатай цахим сүлжээгээр мэдээлэл түгээдэг /**Telegram, Discord, ...**/
- Зохиомлоор үнэ цэнээ нэмэгдүүлэхийн тулд **цуу яриа, ташаа мэдээлэл** тараадаг
- Хүмүүсийн итгэлийг олохын тулд **олны танил** хүмүүсийг оролцуулдаг



ШИНЭЭР БИЙ БОЛСОН ЛУЙВРЫН ТӨРЛҮҮД

“Rug pull”

- **Худал койн** гарган хөрөнгө оруулагчдын мөнгийг залилдаг
- White paper нь **хоёрдмол агуулгатай**, эргэлзээ төрүүлэхүйц
- Сурталчилгаа маш ихээр хийдэг
- **Өндөр өгөөж амладаг**
- Хувьцааны үнэ ихээр хэлбэлздэг

“Covid-19 scam”



- Цаг үеийн нөхцөл байдал эсвэл вакцины талаар мэдээлэл авахын тулд **хувийн болон дансны мэдээллээ** бичихийг шаарддаг
- Зах зээлээс хэт хямд үнээр эмчилгээний бүтээгдэхүүн зарахыг санал болгодог
- Дээрх тохиолдолд урьдчилгаа төлбөр шилжүүлэхийг шаарддаг



1821 онд Шотланд улсын иргэн болох Генерал Грегор Макгрегор Төв Америкаас Их Британи хүртэл завиар явахдаа **ПОЯИСЫН АРЛЫГ** нээн илрүүлжээ.

Тэрээр арлыг алтны нөөц ихтэй, хөрсний шим сайтай тул жилд 3 удаа ургац хураах боломжтой талаар дуулгахад **ХҮМҮҮС ИХЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙЖ, ОДООГИЙН ХАНШААР 20 САЯ ДОЛЛАР** цугларсан.

ГЭВЧ ЭНЭ БҮГД ЛУЙВАР БАЙСАН ба бодит байдал дээр Пояис нэртэй ямар ч арал байгаагүй.



ТА САНХҮҮГИЙН ЛУЙВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ ЮУ?

Та 2 болон түүнээс дээш асуултад **“ТИЙМ”** гэж хариулсан бол **ТА САНХҮҮГИЙН ЛУЙВАРТ ӨРТӨХ ЭРСДЭЛТЭЙ БАЙНА.**

- 1 Танд бага эсвэл ямар ч эрсдэлгүй өндөр өгөөж амлаж байна уу?
- 2 Таны хөрөнгө оруулах гэж буй салбар төрийн зохицуулалтгүй юу?
- 3 Таныг төлбөрөө төлөхийг яаруулж байна уу?
- 4 Танд асуулт асуух боломж олгож байна уу?
Таны асуултад оновчтой хариулж байна уу?
- 5 Шагнал, бэлэг авахын тулд урьдчилгаа төлбөр төлөхийг шаардаж байна уу?
- 6 Одоо л-д хөрөнгө оруулахгүй бол “Сайхан боломжийг алдана” гэж шууд болон шууд бусаар үнэмшүүлж байна уу?

